



## ШУВУУНЫ ТОМУУ ӨВЧНИЙ ТОХИОЛДОЛ ТАРХАЛТЫН МЭДЭЭ

Хоёр долоо хоног тутмын мэдээ №4

### **НЭГ. Шувууны томуугийн А хүрээний вирусийн шувууны өвчлөлийн хураангуй мэдээлэл:**

2020 оны 3 дугаар сарын 02-16 ны хооронд шувууны томуугийн А хүрээний вирус Словак, Болгар, Тайвань, Украин зэрэг оронд шувуунд илрээд байна. Словак -д 4 удаагийн өвчлөл бүртгэгдэж 20, Болгар улсад 4 удаа өвчлөл бүртгэгдэж 9947, Тайвань улсад 2 удаа өвчлөл бүртгэгдэж 1442, Украин улсад 1 удаа өвчлөл бүртгэгдэж 7856 тэжээмэл шувууд өвчилж үхсэн байна (хүснэгт 1, зураг 1).

### **ХОЁР. Шувууны томуугийн А хүрээний (H5N1) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2020 оны 3 дугаар сарын 02-16 ны хооронд шувууны томуугийн А хүрээний H5N1 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн тохиолдол бүртгэгдээгүй байна.

### **ГУРАВ. Шувууны томуугийн А хүрээний (H5N6) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

Мөн хугацаанд шувууны томуугийн А хүрээний H5N6 вирусээр үүсгэгдсэн хүний өвчлөлийн тохиолдол шинээр бүртгэгдээгүй байна.

### **ДӨРӨВ. Шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2020 оны 3 дугаар сарын 02-16 ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H7N9) вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна.

### **ТАВ. Шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2020 оны 03 дугаар сарын 02-16 ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H9N2) вирусийн хүний өвчлөлийн 2 тохиолдол бүртгэгдсэн байна. Эхний тохиолдол нь Хонгконг улсад 7 настай хүү өвчилсөн бөгөөд тухайн улсын хувьд 2013 оноос хойш хүний өвчлөлийн 9 дахь тохиолдол болсон байна. 2020 оны 02-р сарын 04 нд хүү өвдөж эхэлсэн бөгөөд дараагийн өдөр нь эмнэлэгт хандсан байна. Тархвар судлалын асуумжаар хүү Хятад улсын Гуандонг мужид хувийн тахианы аж ахуй эрхэлдэг хамаатнууд дээрээ зочилж байсан. Зочлох хугацаандаа хүү шувуудад ойртоогүй. Дараагийн тохиолдол нь Сенегал улсад бүртгэгдсэн. Мөн хүүхэд байсан ба тухайн улсын хувьд анхны тохиолдол байв. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлсэнээр томуугийн А хүрээний (H9N2) вирус нь сүүлийн жилүүдэд Африк тивийн улсуудад тахианы аж ахуйн хүрээнд ихээр мэдээлэгдэх болсон. H9N2 вирус нь хоруу чанар бага, энэ өвчнөөр хүн нас барсан тохиолдол байхгүй.

### **ЗУРГАА. Шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусийн хүний өвчлөлийн дэлгэрэнгүй мэдээлэл:**

2020 оны 3 дугаар сарын 02-16 ны хооронд шувууны томуугийн А хүрээний (H7N4) вирусийн хүний өвчлөлийн шинэ тохиолдол бүртгэгдээгүй байна. 2018 оны 2 дугаар сарын 14-нд хүний өвчлөлийн анхны тохиолдол БНХАУ-ын Жинсу мужид бүртгэгдсэн.


**ДОЛОО. 2020 оны 3 дугаар сарын 02 ноос 3 дугаар сарын 16-ныг хүртлэх хугацаанд шувууны томуугийн А хүрээний вирусээр өвчилсөн шувууны мэдээлэл:**

(Хүснэгт 1) Шувууны томуугийн А хүрээний вирусийн тархалт болон вирусийн хэлбэр

Шувууд өвчилж эхэлсэн өдөр	Хэлбэр	Улс	Муж	Өртсөн нийт шувуудын тоо	Үхсэн
9/1/2020	H5N8	Словак	Нитра	22	3
9/1/2020	H5N8	Словак	Трава	19	4
9/1/2020	H5N8	Словак	Трэчин	9	9
9/1/2020	H5N8	Словак	Зилина	10	4
17/02/2020	H5N8	Болгар	Пловдив	15729	9899
17/02/2020	H5N8	Болгар	Пловдив	3620	0
17/02/2020	H5N8	Болгар	Пловдив	5000	0
17/02/2020	H5N8	Болгар	Пловдив	31322	44
24/02/2020	H5N2	Тайвань	Янлин	1151	191
24/02/2020	H5N5	Тайвань	Янлин	11988	1251
18/01/2020	H5	Украйн	Винниц	116544	7856

Эх сурвалж: *Oie.int*

(Зураг 1) Шувууны томуугийн А хүрээний вирусийн тархалт /зургаар/



## ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ

*Шувууны томуу хариуцсан баг*